



БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН
АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Улаанхус сумын ТТЗ-ийн
2016 оны 12 дугаар сарын 31-нээр
дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлан

Аудитын код: БӨА-2017/2/СТА-ТТЗ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл дараах хаягаар харилцана уу:

Цахим хуудас: ulaanhus.bo.gov.mn

Тэргүүлэх аудитор: М.Хуанган

Утас: 99417382 Цахим хаяг: mhkuangan@yahoo.com

Аудитын менежер: Х.Женисбек

Утас: 70422930, 99932710 Цахим хаяг: kh_jenisbek@yahoo.com

Аудитор: М.Айнур 94159291

Утас: Цахим хаяг:

Агуулга

1	Аудитын гэрчилгээ	2
2	Аудитын тайлан	4
2.1	Оршил	4
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
2.3	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	5
2.4	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	5
2.5	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	6
2.6	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	6
2.7	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	7
2.8	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	7
2.9	Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл	8
2.9.1	Төлбөрийн акт тогтоосон алдаа, зөрчилтэй асуудал	9
2.9.2	Албан шаардлага өгсөн алдаа, зөрчилтэй асуудал	9
2.9.3	Сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал	9
2.9.4	Хууль хяналтын байгууллагад асуудлыг шилжүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал	9
2.10	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	9
2.11	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	9
2.12	Шилэн дансны мэдээлэл	15
2.13	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	15
2.14	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	16
3	Менежментийн захидал	18
3.1	«management_zurchil1»	Error! Bookmark not defined.
3.2	«management_zurchil2»	Error! Bookmark not defined.
4	Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл	18
4.1	Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	21
4.2	Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	24
4.3	Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан ..	Error! Bookmark not defined.
4.4	Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	30
4.5	Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	37

1 Аудитын гэрчилгээ



УЛААНХУС СУМЫН ЗАСАГ ДАРГА
О.НУРЛАН ТАНАА

**ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬАА
БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН
АУДИТЫН ГАЗАР**

83129 Өлгий сум, Баян-Өлгий аймаг,
Утас/факс: (976) 7042-2954
E-mail: bayanulgiu@audit.gov.mn

8074 К.З.20 № 12 ДТ. 2017/12/07 - ТТЗ
танай _____-ны № _____-т

Г Аудитын гэрчилгээ 1

Улаанхус сумын Засаг даргын төсвийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх дуусвар болсон, аккруэл сууриар бэлтгэгдсэн, жилийн эцсийн нэгдсэн санхүүгийн тайланд Төрийн аудитын тухай хуулийн 15.2.1-д заасан бүрэн эрхийн дагуу аудит хийв.

Улаанхус сумын Засаг даргын нь тайлант хугацааны санхүүгийн тайланг холбогдох хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу үнэн зөв бэлтгэж, тайлагнах үүрэг, хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллага нь Улаанхус сумын Засаг даргын 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, санал дүгнэлт өгөх үүрэг, хариуцлага хүлээнэ.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журмын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, журам нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Улаанхус сумын Засаг даргын 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийн хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем, гол хууль тогтоомжуудын мөрдөлтийг болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан материаллаг алдаагүй эсэхэд санал дүгнэлт өгөх хангалттай бөгөөд зохистой үндэслэлийг бүрдүүлсэн.

Улаанхус сумын Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар илэрсэн дараах зөрчлүүд нь Оршин байх, Тохиолдсон байх, Иж бүрэн байх, Үнэлгээ, Хэмжилт, Толилуулга ба тодруулга, Үнэн зөв байдал зэрэг батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна. Үүнд:

1. ОНХСангийн 15.8 сая төгрөгийн санхүүжилтийн авлага, байгууллагад төлөх 13.2 сая төгрөгийн өглөгийг санхүүгийн тайланд тусгаж харуулаагүй, Төсвийн гүйцэтгэлийн тайланг 62.4 сая төгрөгөөр алдаатай нэгтгэсэн, Мөнгөн гүйлгээний тайланд 35.8 сая төгрөгийн нэмэлт санхүүжилтийг орлого, зарлагад дутуу тусгасан, 36.8 сая төгрөгний хөрөнгө оруулалтын мөнгөн гүйлгээг зөв ангилж тусгаагүй, Үр дүнгийн тайланд хөрөнгийн санхүүжилтийн дүнг 142.3 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан, Нэмэлт санхүүжилтийн тайланд санхүүжилтийн дүнг 16.9 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан зэргээр санхүүгийн нэгтгэсэн тайланг нийтдээ 323,9 сая төгрөгийн алдаа зөрчилтэй гаргасан.

Хязгаарлалттай санал дүгнэлт

Дээрхи алдаа зөрчлийн санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөллийг эс тооцвол Улаанхус сумын Засаг даргын төсвийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлан, илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн байна.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



М.ХУАНГАН

2 Аудитын тайлан

2.1 Оршил

Улаанхус сумын Засаг дарга О.Нурлан танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг биш алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж, оруулав.

2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15.2-д заасан бүрэн эрхийн хүрээнд энэ хуулийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8.9.2 дах заалтыг хэрэгжүүлэх зорилгоор Улаанхус сумын Засаг даргын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийлээ.

Аудитыг төлөвлөлтийн шатанд боловсруулсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Улаанхус сумын Засаг даргын 2016 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт, түүнд нийцүүлэн гаргасан төр, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2017 оны 3-р сарын 20-наас 2017 оны 3-р сарын 25-ны хооронд хийж, аудитын тайланг 2017 оны 3-р сарын 25-нд эцэслэн баталгаажуулж, үйлчлүүлэгчийн удирдлагад хүргүүлэхээр төлөвлөн, Улаанхус сумын Засаг даргын ТТЗ-ийн тайланг Аймгийн аудитын газрын аудитор М.Айнур хариуцаж хэрэгжүүлэв.

Улаанхус сумын Засаг даргын 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг 2017 оны 3-р сарын 06-нд төрийн аудитын байгууллагад 2017 оны 3 сарын 03-ны өдрийн 1/73 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

2.3 Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн аудитын журам, гарын авлагад дурдсан аудитыг төлөвлөх, гүйцэтгэх, тайлагнах үе шатны ажлыг гүйцэтгэж, баримтжуулан Санхүүгийн тайлангийн аудитын удирдлагын системд оруулсан бөгөөд аудитад баримтласан бодлого, стандарт, зарчим, үйл явцын талаарх мэдээллийг аудитын санал дүгнэлтэд тодорхойлсон болно.

Аудитын үйл явц, үр дүнг Аудитын олон улсын стандартын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудит хийхэд Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандарт, Санхүүгийн аудитын удирдамж – Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт 1000 – 1810, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчмуудад тулгуурлав.

2.4 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид Аудитын олон стандартад зааснаар үйлчлүүлэгч байгууллагын үйл ажиллагаа, гадаад дотоод орчны талаар төлөвлөсөн бодлого, журмын дагуу шаардлагатай гэж үзсэн хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Улаанхус сумын Засаг дарга *“Сум орон нутгийг бие даан хөгжүүлэх замаар иргэний эрүүл мэндийг хамгаалах, ажилтай орлоготой болгох, өсвөр үеийнхэнд чанартай боловсрол олгох, сурч боловсрох таатай орчин бүрдүүлэх, төрийн ажлыг жигд хүртээмжтэй болгох, иргэдийнхээ амьдрах орчныг сайжруулах”* эрхэм зорилгын дор аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээнд дараах үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна.

Улаанхус сумын Засаг дарга дээрх хуулиар тогтоосон чиг үүрэг, үйл ажиллагааны хүрээнд өөрийн эрхэлэх асуудал, үйл ажиллагааныхаа чиглэл, цар хүрээг дараах байдлаар тодорхойлж баталгаажуулжээ. Үүнд:

Тайлант хугацаанд Улаанхус сумын Засаг дарга *“Хүн ам, өрх гэр бүлийг дээдэлсэн төрийн бодлогыг тэгш хүртээмжтэй болгох, эрүүл мэнд, боловсрол соёлын хүртээмжийг сайжруулан, ажилтай, орлоготой өрх гэрийн төлөө”* зорилт дэвшүүлэн ажиллажээ.

Улаанхус сумын Засаг даргын талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, ТАБ-СТА-Б-2.1 маягтаар баталгаажуулсан болно.

Улаанхус сумын Засаг дарга удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан

бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт ороогүй байна.

2.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн нэгтгэсэн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Улаанхус сумын Засаг даргын төсөв, санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд эрсдэлгүй буюу мэдээллийн технологийн мэргэжилтэн аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзлээ.

Улаанхус сумын Засаг дарга санхүүгийн тайлан, тодруулга, төсвийн гүйцэтгэлийн тайлан бэлтгэх, ажил гүйлгээг бүртгэх, хянах үйл ажиллагаанд санхүүгийн “Пластик”, “Аколоус” програм хангамж ашиглажээ.

2.6 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Улаанхус сумын Засаг даргын бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой уламжлалт болон хяналтын эрсдэлийг илрүүлэх, үнэлэх үе шатны ажлын талаар товч толилуулъя.

Аудитыг төлөвлөх үе шатанд байгууллага, түүний гадаад, дотоод орчны талаарх цуглуулсан мэдээлэл, ойлголтод үндэслэн эрсдэлийн үнэлгээний горим хэрэгжүүлэн 14 эрсдэлтэй асуудал тодорхойлон, тэдгээрийг ТАБ-СТА-Б-2.6 маягтад нэгтгэж, баримтжуулав.

Дээрх эрсдэлтэй асуудал тус бүрийг дахин нарийвчлан үнэлэхэд 1 асуудал эрсдэл өндөр, 8 асуудал эрсдэл дунд, эрсдэл багатай асуудал байхгүй гэсэн үр дүн гарлаа.

Эрсдэлийн ерөнхий үнэлгээг ТАБ-СТА-Б-4.3 маягтад нэгтгэн баримтжуулсан бөгөөд нийт эрсдэлийн үнэлгээний түвшин 27 байна.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн эрсдэл өндөр буюу зайлшгүй шалгах эрсдэлтэй асуудлыг аудитын чиглэл тус бүрээр нэгтгэж, тэдгээрийг сорих – шалгах аудитын горим сорил, шалгуур үзүүлэлт, нотлох зүйл цуглуулах арга замыг холбогдох маягтаар баримтжуулан баталгаажуулсан болно.

2.7 МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үеийн материаллаг байдлыг Аудитын олон улсын стандарт 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн байдлын тайлангийн нийт хөрөнгийг сонгов.

Санхүүгийн байдлын тайлангийн нийт хөрөнгийг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь Орон нутгийн төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлан тул нийт хөрөнгийг материаллаг байдлыг тооцох суурь үзүүлэлтээр сонгох нь тохиромжтой гэж үзсэнтэй холбоотой юм.

Улаанхус сумын Засаг даргын 2016 оны санхүүгийн тайлангийн нийт хөрөнгө 9172,7 сая төгрөг бөгөөд түүний 1 хувь 91,7 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс тооцох хувийг 1 хувиар тооцсон нь эрсдэлийн үнэлгээний түвшин өндөр үнэлгээтэй гарсантай холбоотой юм.

2.8 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, төлөвлөсөн ёсоор аудитын 4 чиглэлээр 11 эрсдэлтэй асуудалд 11 горим, сорил хэрэгжүүлж, түүний үр дүнг баримтжуулав. /ТАБ-СТА-В-3.1/

Дээрх горим сорилыг хэрэгжүүлэн тэдгээрийн гол үр дүн, нөхцөл байдлыг үнэлэхэд хэрэгжүүлсэн нийт горим сорилын 37 хувь буюу 3 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэв. /ТАБ-СТА-В-4.1/

Харин аудитыг төлөвлөх шатанд эрсдэлтэй гэж тооцсон боловч, аудитын горим сорил хэрэгжүүлэх явцад алдаа зөрчилгүй нь тогтоогдсон асуудлыг ТАБ-СТА-В-4.2 маягтаар нэгтгэж, баримтжуулав.

Алдаа зөрчилтэй буюу буруу илэрхийллийн нэгтгэлээс аудитын явцад залруулах боломжтой ОНХСангийн 15,9 сая төгрөгийн авлага, 13,2 сая төгрөгийн өглөг, тайлагналтай холбоотой бусад төрлийн 294.5 сая төгрөгийн алдаа зөрчилтэй асуудлыг ТАБ-СТА-В-4.3 маягтад шийдвэрлэж, залруулах боломжтой асуудал буюу залруулгын талаарх мэдээллийг ТАБ-СТА-В-4.4, ТАБ-СТА-В-4.5 маягтуудад нэгтгэж, баримтжуулсан.

Харин санхүүгийн тайлан, тодруулга дах залруулаагүй буруу илэрхийлэл буюу алдаа зөрчилтэй асуудалд дүн шинжилгээ хийж, алдаа зөрчлийг дараах байдлаар ангилав.

(Сая төгрөгөөр)				
№	Буруу илэрхийлэл буюу алдаа зөрчлийг ангилсан байдал	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж болгосон асуудал	0	0	
2	Төлбөрийн акт тогтоосон	1	0,3	
3	Албан шаардлага өгсөн	0	0	
4	Сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн	0	0	
5	Хууль хяналтын байгууллагад асуудлыг шилжүүлсэн	0	0	
Дүн		1	0.3	

Дээрх зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүй жагсаалтыг ТАБ-СТА-В-4.6.1-5 маягтад нэгтгэн баримтжуулав.

2.9 Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл

Санхүүгийн тайланд нийтдээ 323.6 сая төгрөгийн алдаа зөрчлийг залруулга хийлээ.Залруулга хийсэн алдаа зөрчлийг дэлгэрэнгүй харуулбал:

1. ОНХСангийн 2016 оны батлагдсан төсөвт аймгийн ОНХСангийн төсвөөс дутуу олгосон 15.9 сая төгрөгийн орлогын шилжүүлэгийг санхүүгийн тайланд санхүүжилтийн авлагаар тусгаж харуулаагүй орхигдуулсан,
2. ОНХСангийн хөрөнгөөр 2016 онд хэрэгжсэн зарим төсөл арга хэмжээний дутуу олгогдсон 13.2 сая төгрөгийн ажлын гүйцэтгэлийн санхүүжилтийн өглөгийг санхүүгийн тайланд өглөгөөр тусгаж харуулаагүй орхигдуулж Төсвийн тухай хуулийн 26.1 "Төсвийн байгууллага нь НББОУС болон үндэсний стандартын дагуу бүрэн аккрузл суурьтай нягтлан бодох бүртгэл хөтлөнө" гэсэн заалтыг зөрчсөн.
3. Төсвийн гүйцэтгэлийн тайланг 62.4 сая төгрөгөөр илүү илэрхийлж, Сангийн сайдын 2012 оны 76 тоот тушаалаар баталсан Төсвийн гүйцэтгэлийн тайлан боловсруулах журмыг зөрчсөн байна.
4. МГТайланд Үндсэн хөрөнгө худалдан авсан 36.8 сая төгрөгний гүйлгээг Хөрөнгө оруулалтын мөнгөн гүйлгээний хэсэгт биет хөрөнгө худалдан авсанаар зөв ангилж тусгаагүй
5. Үр дүнгийн тайлангийн хөрөнгийн санхүүжилтийг 117.3 сая төгрөгөөр тусгаж, бодит гүйцэтгэлийн дүнгээс 142.3 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан.
6. ҮДТ-д үнэ төлбөргүй авсан бараа материалыг 0.4 сая төгрөгөөр илүү тусгаж, тайлагнасан
7. Нэмэлт санхүүжилтийн тайланд санхүүжилтийн дүнг 42.7 сая төгрөгөөр тусгаж, бодит гүйцэтгэлээс 16.9 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан.
8. МГ-ний тайланд 35.8 сая төгрөгийн нэмэлт санхүүжилтийг орлого, зарлагад оруулаагүй орлого, зарлагын дүнг буруу илэрхийлсэн

2.9.1 Төлбөрийн акт тогтоосон алдаа, зөрчилтэй асуудал

Аймгийн төсөвт төвлөрүүлэх орлогоос 247,1 мянган төгрөгийг дутуу төвлөрүүлснийг нөхөн төлүүлэхээр акт тогтоосон.

2.9.2 Албан шаардлага өгсөн алдаа, зөрчилтэй асуудал

Үгүй

2.9.3 Сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал

Үгүй

2.9.4 Хууль хяналтын байгууллагад асуудлыг шилжүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал

Үгүй

2.10 ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ БУЮУ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

ОНХС, СХСангийн авлага, өглөгийн бүртгэл тооцоо, баталгаажуулалт, Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн нэгтгэл, гаргалт.

2.11 Төсвийн гүйцэтгэл, САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙН ТАЛААРХ ТАЙЛБАР, ТОДРУУЛГА**1. Мөнгөн хөрөнгийн бүртгэл, тайлагнал**

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	44,240,697.68	26,421,058.68
311	Кассанд байгаа бэлэн мөнгө	52.00	1,486.50
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	44,240,645.68	26,419,572.18
3121	Төгрөг	44,240,645.68	26,419,572.18
31211	Төрийн сангийн харилцах	39,921,842.68	16,667,008.68
31212	Монгол банкин дахь харилцах		
31213	Арилжааны банк дахь харилцах	4,318,803.00	9,752,563.50

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангаар оны эцэст нийтдээ 26,4 сая төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй гарчээ. Мөнгөн хөрөнгийн бүтцийг авч үзвэл нийт үлдэгдэл мөнгөний 9,7 сая төгрөг нь арилжааны банкин дахь, 16,7 сая төгрөг нь төрийн сан дахь харилцах дансны үлдэгдэл байна. Үүнд: ЗДТГ-ын арилжааны банкин дахь үлдэгдэл 9,7 сая төгрөг, Орон нутгийн орлогын данс үлдэгдэл 16,7 сая төгрөг байна.

Арилжааны банкинд байгаа 9711,2 мянган төгрөг нь ЗДТГ-ын, 3,3 мянган төгрөгийн үлдэгдэл ахлах сургуулийн, 38,1 мянган төгрөгийн үлдэгдэл эргэлтийн эмийн сангийн үлдэгдэл байна.

2. Авлагын бүртгэл, тайлагнал

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	зөрүү
33	АВЛАГА	297,001,977.65	422,722,356.65	125,720,379.00
33300	Татаас, санхүүжилтийн авлага		15,870,200.00	15,870,200.00

335	Бусад авлага	297,001,977.65	406,852,156.65	109,850,179.00
3351	Байгууллагаас авах авлага	1,612,632.65	1,612,632.65	-
3352	Хувь хүмүүсээс авах авлага	295,389,345.00	405,239,524.00	109,850,179.00

Санхүүгийн тайлан дахь авлагын үлдэгдэл өмнөх оноос 125,7 сая төгрөгөөр нэмэгдсэн дүнтэй байна. Санхүүгийн албанаас сум хөгжүүлэх сангийн зээлийн авлагын өмнөх оны үлдэгдлийг харилцагч бүрээр тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, залруулга хийсэнтэй холбоотой үлдэгдэл оны эхнээс 109,8 сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Сум хөгжүүлэх сангийн зээлийн авлагыг тооцоо нийлж, зээлдэгч нэг бүрээр гарын үсэг зуруулж үлдэгдлийг баталгаажуулаагүй байна. ОНХСангийн 2016 оны батлагдсан төсвөөс дутуу авсан 15,8 сая төгрөгийн санхүүжилтийг санхүүгийн тайланд авлагаар харуулаагүй байсныг залруулав.

3. Бараа материалын бүртгэл, тайлагнал

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	зөрүү
35	БАРАА МАТЕРИАЛ	316,128,646.88	381,744,974.27	65,616,327.39
351	Түүхий эд материал	8,445,038.00	4,236,409.40	(4,208,628.60)
354	Хангамжийн материал	294,870,393.88	360,934,921.87	66,064,527.99

Бараа материалын үлдэгдэл оны эхнээс 65,6 сая төгрөгөөр өссөн байна. Тайлант онд бичиг хэрэг, түлш шатах тослох материал, аж ахуйн материал, барилгын материал, хүнсний материал, бусад хангамжийн материалын үлдэгдэл өнгөрсөн оноос өссөн дүнтэй байгаа бол түүхий эд материалын материалын үлдэгдэл урьд оноос буурсан дүнтэй байна. Тайлант онд нийтдээ 4,6 сая төгрөгийн материалыг үнэ төлбөргүй хүлээн авсан байна.

4. Үндсэн хөрөнгийн бүртгэл, тайлагнал

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	зөрүү
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	8,553,885,393.71	8,465,576,460.22	(88,308,933.49)
392	Биет хөрөнгө	8,553,032,143.61	8,465,223,543.82	(87,808,599.79)
393	Биет бус хөрөнгө	853,250.10	352,916.40	(500,333.70)

Үндсэн хөрөнгө оны эхнээс 88,3 сая төгрөгөөр буурсан байна. Тайлант онд 36,8 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг худалдан авч, 259,8 сая төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүй хүлээн авчээ. 22,7 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг данснаас хассан ба үүнээс 19,6 сая төгрөгийн хөрөнгийг акталж, бусдыг данснаас хассан байна.

Тайлант онд үндсэн хөрөнгөнд 374,1 сая төгрөгийн элэгдэл тооцож, 11,9 сая төгрөгийн элэгдлийг хасах бичилт хийж, хуримтлагдсан элэгдлийн үлдэгдэл 4045,5 сая төгрөгт хүрсэн байна.

Төсөвт байгууллагууд нийтдээ 259,8 сая төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүй хүлээн авснаас ЗДТГазар нь 0,1 сая төгрөгийн, Бүрэн дунд сургууль 122,7 сая төгрөгийн, Хөх хөтөлийн дунд сургууль 53,4 сая төгрөгийн, Ойгор сургууль 9,8 сая төгрөгийн, Ойгор цэцэрлэг 0,4 сая төгрөгийн, Соёлын төв 0,3 сая төгрөгийн, Улаанхус цэцэрлэг 54,6 сая төгрөгийн, ЭМТөв нь 18,5 сая төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүй хүлээн авсан байна.

5 .Өр төлбөрийн бүртгэл, тайлагнал

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	<u>Эхний үлдэгдэл</u>	<u>Эцсийн үлдэгдэл</u>	Зөрүү
413	Өглөг	<u>103,991,559.11</u>	<u>55,614,112.00</u>	<u>(48,377,447.11)</u>
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	12,335,659.00	2,194,538.00	(10,141,121.00)
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	5,605,879.80		(5,605,879.80)
4136	Бусад өглөг	86,050,020.31	53,419,574.00	(32,630,446.31)
41361	Байгууллагад төлөх өглөг	69,965,082.00	53,419,574.00	(16,545,508.00)
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	16,084,938.31		(16,084,938.31)

Оны эхэнд 103,9 сая төгрөгийн өглөгтэй байсан ба оны эцэст 55,6 сая төгрөг болж, 48,4 сая төгрөгөөр буурсан байна. Оны эцэст Бүрэн дунд сургууль 27,4 сая төгрөгийн, Эрүүл мэндийн төв 10,2 сая төгрөгийн, Хүүхдийн цэцэрлэг 4,8 сая төгрөгийн өглөгтэй байна.

6. Орлого, татаас санхүүжилтийн талаар

6.1 Улсын төсвийн санхүүжилт

Улаанхус сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлангаар тайлант онд тусгай зориулалтын шилжүүлгээр нийтдээ 4319,1 сая төгрөгийн санхүүжилт, 63,6 сая төгрөгийн нэмэлт санхүүжилтийг хүлээн авсан байна.

6.2 Орон нутгийн төсвийн санхүүжилт

Орон нутгийн захиргааны байгууллагуудад аймгийн төсвөөс 324,3 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг хүлээн авч, орон нутгийн татварын орлогоос 112,6 сая төгрөгийн орлогын эх үүсвэр бүрдүүлэн санхүүжүүлсэн байна. Нэмэлт санхүүжилтээр 63,6 сая төгрөг хүлээн авчээ.

6.3 Өөрийн орлого

Улаанхус сумын төсөвт байгууллагуудад үндсэн үйл ажиллагааны орлогоос 980,0 мянган төгрөгийн орлого оруулах төлөвлөгөө өгөгдсөнөөс 569,0 мянган төгрөгийн орлого оруулсан байна.

6.4 Татварын орлого

Улаанхус сумын ИТХ-аас сумын 2016 оны Орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөг анх 41,2 сая төгрөгөөр баталжээ. Тодотголоор 96,1 сая төгрөгөөр нэмж баталсан байна.Орлогын бүтцийг авч үзвэл нийт орлогын 14,0 хувийг ХАОАТатвараас, 86,0 хувийг бусад татвараас оруулахаар төлөвлөжээ.

Орон нутгийн төсвийн орлогын гүйцэтгэлийг хүснэгтээр харуулбал:

/тəгрəг/

1	ᠶᠡᠳᠡᠭᠦᠨ ᠲᠤᠯᠥᠪᠯᠡᠭᠡ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
	Нийт орлого ба тусламжийн дүн				
	A.Урсгал орлого	96,128,000.0	112,626,755.00	16,498,755.0	117%
	I.Татварын орлого	96.103.000.0	112.506.755.0	16.403.755.0	117%

	1.Орлогын албан татвар	13,500,000.0	18,529,945.00	5,029,945.0	137%
	1.1 ХАОАТатвар	13,500,000.00	18,529,945.00	5,029,945.00	137%
	2.Өмчийн татвар		134,750.00	134,750.0	-
	4.Бусад татвар	82,603,000.00	93,842,060.00	11,239,060.0	114%
	II.Татварын бус орлого	0.0	90,000.0	90,000.0	-
	Б.ХӨРӨНГИЙН ОРЛОГО	25,000.0	30,000.0	5,000.0	120%

Гүйцэтгэлээр Орон нутгийн орлогод нийтдээ 112,6 сая төгрөг төвлөрүүлж төлөвлөгөөг 16,5 сая төгрөгөөр буюу 117 хувиар давуулан биелүүлсэн байна. Нийт орлогын 61,4 хувийг ХАОАТатварын, 35,0 хувийг бусад татварын, 9,4 хувийг татварын бус орлого бүрдүүлж байна.

Орлогын нэр төрлөөр авч үзэхэд ХАОАТатвар 5029,9 мянган төгрөгөөр буюу 137,0 хувиар, бусад татвар 11239,1 мянган төгрөгөөр буюу 114 хувиар биелэгдэж, өмчийн татвараас 134,7 мянган төгрөг, татварын бус орлогоос 90,0 мянган төгрөг, хөрөнгийн орлогоос 30,0 мянган төгрөг тус тус орсон байна.

Орон нутгийн орлогын 995 тоот дансанд оны эхэнд үлдэгдэлгүй ба тайлант онд 112,6 сая төгрөгийн татварын орлого оруулж, 130,7 сая төгрөгийг зарлагадаж, оны эцэст орон нутгийн төсвийн ерөнхий орлогын 910 тоот дансанд 16,7 сая төгрөгийн үлдэгдэлтэй гарчээ.

6.5 Бусад

Тайланд онд ОНХСангийн санхүүжилтэнд 116,8 сая төгрөгийн санхүүжилт авч, бусад орлогоос 2,0 сая төгрөгийг оруулж, Сум хөгжүүлэх сангийн эргэн төлөлтөөс 26,9 сая төгрөгийг, Эргэлтийн эмийн сан 9,5 сая төгрөгийн орлогыг оруулсан байна.

7. Зарлага санхүүжилтийн талаар

7.1 Санхүүжилтийн зарцуулалт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар батлагдсан төсвийн гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулж, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Улаанхус сумын ТТЗ-ийн өөрийн чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой төсөвт байгууллагуудын хөтөлбөр, арга хэмжээнд зориулан 2016 оны урсгал зардалд нийтдээ 4907,7 сая төгрөгийн төсөв батлагдсаны 4319,1 сая төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгээр, 455,0 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, 132,7 сая төгрөгийг ОНХСангийн хөрөнгөөр, 0,1 сая төгрөгийг үйл ажиллагааны орлогоор санхүүжүүлэхээр төлөвлөсөн байна.

Гүйцэтгэлээр тусгай зориулалтын шилжүүлгээр 4319,1 сая төгрөгийн, орон нутгийн төсвөөс 455,0 сая төгрөгийн, аймгийн ОНХСангаас орлогын шилжүүлгээр 116,8 сая төгрөгийн санхүүжилт авч, бусад орлогоос 2,0 сая төгрөгийн, бүгд дүнгээр 118,8 сая төгрөгийн, үндсэн үйл ажиллагааны орлогоос 0,6 сая төгрөгийн орлого оруулж, бүгд дүнгээр 4886,9 зарлага санхүүжилтээр ажиллаж, батлагдсан төсвөөс нийт дүнгээр 20,8 сая төгрөгөөр бага зарлага гаргажээ.

Энэ нь аймгийн ОНХСангаас 15,9 сая төгрөгийн санхүүжилтийг дутуу олгосон, ОНХСангаас 11,9 сая төгрөгийн санхүүжилтийг зарцуулаагүй үлдэгдэлтэй, сумын ЗДТГ нь арилжааны банкинд 9,7 сая төгрөгийн зарцуулаагүй үлдэгдэлтэй гарч, төсөвт байгууллагуудаас 0,3 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлсэнтэй холбоотой байна. Үүнд: ЭМТөв 0,2 сая төгрөгийг, Соёлын төв 0,1 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэлийн талаарх мэдээллийг дор нэгтгэн харуулав.

/ сая төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь	Зөрүү
1	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	4907,7	4886,9	99,58%	20,8
1.1	Урсгал зардал	4907,7	4886,9	99,58%	20,8
1.2	Хөрөнгийн зардал	0	0	0.0%	0.0
2	Зардлыг сахүүжүүлэх эх үүсвэр	4907,7	4886,9	99,58%	20,8
2.1	Улсын төсвөөс санхүүжих /Тусгай зориулалтын шилжүүлэг/	4319,1	4319,1	100%	-
2.2	Орон нутгийн төсвөөс	455,0	455,0	100%	-
2.3	Орон нутгийн хөгжлийн сангаас	132,7	118,8	91,94%	13,9
2.4	Төсөвт байгууллагын үйл ажиллагааны орлогоос	0,9	0,6	58,06%	0,4

Төсвийн гүйцэтгэлийг зардлын зүйл ангиар авч үзвэл: НДШ-ийн зардал, нормавитв зардал, томилолт, зочны зардал, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр, хураамж, бараа үйлчилгээний бусад зардлыг 0,3-19,4 сая төгрөгөөр хэмнэж, цалин хөлс, нэмэгдэл урамшил цалин, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал, хангамж бараа материалын зардал, эд хогшил урсгал засварын зардал, урсгал шилжүүлгийн зардлыг 0,09-13,9 сая төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан байна.

Төсвийн гүйцэтгэлийг зардлын зүйл ангиар харуулбал:

/төгрөг/

	үзүүлэлт	төлөвлөгөө	гүйцэтгэл	зөрүү	хувиар
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	4,907,748,000.00	4,886,923,336.00	(20,824,664.00)	99.58
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,775,077,900.00	4,764,950,947.00	(10,126,953.00)	99.79
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,432,334,100.00	4,422,109,937.00	(10,224,163.00)	99.77
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,893,477,200.00	2,907,456,352.00	13,979,152.00	100.48
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	317,839,300.00	317,494,608.00	(344,692.00)	99.89
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	385,448,018.00	388,472,620.01	3,024,602.01	100.78
2104	Хангамж, бараа материалын зардал	92,139,400.00	92,172,495.01	33,095.01	100.04
2105	Нормативт зардал	527,656,100.00	508,275,732.82	(19,380,367.18)	96.33
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	26,535,782.00	28,476,452.00	1,940,670.00	107.31
2107	Томилолт, зочны зардал	11,664,400.00	10,672,300.00	(992,100.00)	91.49
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	21,272,500.00	20,053,541.05	(1,218,958.95)	94.27

Улаанхус сумын ТТЗ-ийн 2016 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудит

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	156,301,400.00	149,035,836.11	(7,265,563.89)	95.35
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	342,743,800.00	342,841,010.00	97,210.00	100.03
2132	Бусад урсгал шилжүүлэг	342,743,800.00	342,841,010.00	97,210.00	100.03
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	132,670,100.00	121,972,389.00	(10,697,711.00)	91.94
2200	Дотоод эх үүсвэрээр	132,670,100.00	121,972,389.00	(10,697,711.00)	91.94
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	4,907,748,000.00	4,883,750,947.00	(23,997,053.00)	99.5
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	4,451,760,200.00	4,437,885,347.00	(10,702,464.00)	99.76
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	4,319,090,100.00	4,319,085,347.00	(4,753.00)	100.00
131008	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	132,670,100.00	118,800.000	(13,870,100.00)	89.5
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	455,007,800.00	445,296,600.00	(9,711,200.00)	97.87
132001	Орон нутгийн төсвөөс	455,007,800.00	445,296,600.00	(9,711,200.00)	97.87
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	-	-	-	#DIV/0!
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	980,000.00	569,000.00	(411,000.00)	58.06
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	980,000.00	569,000.00	(411,000.00)	58.06
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	-	-	#DIV/0!

Төсвийн гүйцэтгэлийг байгууллага бүрээр харуулбал:

/төгрөг/

№	Байгууллагын нэр	Батлагдсан төсөв		Зөрүү	
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	дүнгээр	хувиар
1	Сумын ИТХурал	53,458,400.00	53,458,400.00	-	100.00
2	Сумын ЗДТГазар	401,549,400.00	391,838,200.00	9,711,200.00	97.58
3	Бүрэн дунд сургууль	1,398,891,100.00	1,398,887,834.42	3,265.58	100.00
4	Эрүүл мэндийн төв	547,680,600.00	547,680,600.00	-	100.00
5	Хүүхдийн цэцэрлэг	354,158,700.00	354,158,700.00	-	100.00
6	Соёлын төв	51,274,300.00	50,863,300.00	411,000.00	99.20
7	Ойгор дунд сургууль	739,498,800.00	739,498,799.08	0.92	100.00
8	Согог бал бөбек цэцэрлэг	243,049,100.00	243,047,613.50	1,486.50	100.00
9	Хөх хөтөл дунд сургууль	829,097,400.00	829,097,400.00	-	100.00
10	Хөх хөтөл хүүхдийн цэцэрлэг	156,420,100.00	156,420,100.00	-	100.00
11	ОНХ сан	132,670,100.00	121,972,389.00	10,697,711.00	91.94
	Бүгд	4,907,748,000.00	4,886,923,336.00	20,824,664.00	99.58

Төсөвт байгууллагуудаас ИТХ, ЭМТ, Хүүхдийн цэцэрлэг, Хөх хөтөлийн дунд сургууль, Хөх хөтөлийн цэцэрлэг нь батлагдсан төсвийг бүрэн зарцуулж, бусад төсөвт байгууллагуудын төсвийн зарлага төлөвлөснөөс бага гүйцэтгэлтэй гарсан байна.

7.2 Нэмэлт санхүүжилтийн зарцуулалт

Тайлант хугацаанд Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлд заасан нэмэлт төсвийн дансаар нийтдээ 63,6 сая төгрөгийн орлого хүлээн авч урсгал зардалд 63,6 сая төгрөгийг зарцуулсан байна. Дээрх зардлыг санхүүжүүлсэн эх үүсвэрийг ангилал тус бүрээр нэмэлт төсвийн тайлангаар баримтжуулан баталгаажуулав.

7.3 Тусгай зориулалтын шилжүүлгийн зарцуулалт

Улаанхус сумын 10 төсөвт байгууллага тусгай зориулалтын шилжүүлгээр 4319,1 сая төгрөгийн санхүүжилт авахаар төлөвлөгдсөнөөс 4319,1 сая төгрөгийн буюу санхүүжилтийг бүрэн авчээ.

7.4 Сангийн зарцуулалт

Улаанхус сумын ОНХСан нь оны эхэнд 3,2 сая төгрөгийн үлдэгдэлтэй байсан ба тайлант онд 118,8 сая төгрөгийн санхүүжилт авч, 125,1 сая төгрөгийг сумын ИТХурлаас батлагдсан төсөл арга хэмжээнд зарцуулж, оны эцэст мөнгөн хөрөнгийн төгрөгийн үлдэгдэлгүй гарсан байна.

Сум хөгжүүлэх сангийн харилцах данс оны эхэнд 2,0 сая төгрөгийн үлдэгдэлтэй, тайлант онд эргэн төлөлтөөс 26,8 сая төгрөгийн орлогыг оруулсан ба тайлант онд 28,8 сая төгрөгийг зээл олгож, оны эцэст мөнгөн хөрөнгийн үлдэгдэлгүй гарсан байна.СХСан нь жилийн эцэст 403,2 сая төгрөгийн зээлийн авлагатай байна.

Эргэлтийн эмийн сан оны эхэнд арилжааны банкин дахь харилцах дансандаа 4318,8 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байсан ба тайлант онд 9,5 сая төгрөгийн орлого оруулж, 13,7 сая төгрөгийг зарцуулж оны эцэст 38,1 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

8. Эзэмшигчийн өмчийн талаар

Улаанхус сумын ТТЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлангаар эзэмшигчийн өмч 9107,3 сая төгрөг байснаас 133,5 сая төгрөгөөр нэмэгдэж 9240,8 сая төгрөг болсон байна.Үүнээс ЗГОКапитал 4245,6 сая төгрөг, дахин үнэлгээний нэмэгдэл 1843,7 сая төгрөг, хуримтлагдсан үр дүн 3151,5 сая төгрөг байна. Улаанхус сумын сумын ТТЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлангаар тайлант онд 25,7 сая төгрөгийн үр дүнтэй ажиллаж, хуримтлагдсан үр дүн 3151,5 сая төгрөг болж өссөн дүнтэй байна.

2.12 Шилэн дансны мэдээлэл

Улаанхус сумын ТТЗ Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянав.

2.13 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлт 2016 он оны жилийн эцсийн байдлаар өмнөх оны зөвлөмжийн биелүүлж, биелэлтийг хугацаанд ирүүлсэн байна.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийг Улаанхус сумын Засаг даргын 2016 оны 11 сарын 24-ны өдрийн 1/204 дугаар албан бичгээр манайд ирүүлсэн бөгөөд аудитын явцад шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр биелэлтийн талаарх мэдээллийг дахин нягталсан болно.

2.14 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Улаанхус сумын Засаг даргын 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг Аудитын Олон улсын стандартын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Улаанхус сумын ТТЗ-ийн нэгдсэн тайлангаа нийтдээ 323,9 сая төгрөгийн алдаа зөрчил илэрч санхүүгийн тайланд залруулга хийгдлээ. Энэ нь Оршин байх, Тохиолдсон байх, Иж бүрэн байх, Үнэлгээ, Хэмжилт, Толилуулга ба тодруулга, Үнэн зөв байдал зэрэг батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Дээрхи алдаа зөрчлийн санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөллийг эс тооцвол Улаанхус сумын Засаг даргын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн. Алдаа зөрчлийн санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөллийг тооцож “Хязгаарлалттай” санал дүгнэлт гаргалаа.

Аудитын явцад илэрсэн алдаа зөрчлийг энэ тайлангийн 2.9-д нэгтгэн тусгасан бөгөөд эдгээр буруу илэрхийлэл буюу алдаа, зөрчлийн дүн материаллаг байдлын түвшингээс их байгаа тул аудитын санал дүгнэлтийг хязгаарлах үндэслэл болж байна.

Аудитын санал дүгнэлтийг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

2.15 Төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн талаар

Улаанхус сумын бүх төсөвт байгууллагын санхүүгийн тайланг түүвэрт хамруулж, Төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн дүгнэлтэд оруулсан.

Төсвийн шууд захирагчийн нэр	Алдаа, зөрчлийн дүн /мян. төг/	Аудитор ын санал дүгнэлт бүгд	Үүнээс			
			Зөрчил гүй санал дүгнэлт	Хязгаарлалттай санал дүгнэлт	Сөрөг санал дүгнэлт	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
Сумын ИТХурал		1	1			
Сумын ЗДТГазар	16458,3	1	1			
Бүрэн дунд сургууль		1	1			
Хөх хөтөлийн дунд сургууль		1	1			
Согог дунд сургууль	9379,2	1	1			
ЭМТөв	-	1	1			

Хүүхдийн цэцэрлэг	8284,9	1	1			
Хөх хөтөл хүүхдийн цэцэрлэг	1749,0	1	1			
Согог цэцэрлэг		1	1			
Соёлын төв		1	1			
Сумын ТТЗ-ийн СНТайлан	323 893,9			1		
Дүн	359765,3	11	10	1		

Улаанхус сумын төсөвт байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийтдээ 359,8 сая төгрөгийн алдаа зөрчил илэрч, залруулга хийгдсэн байна. Төсөвт байгууллагуудаас ЗДТГазраас 16,5 сая төгрөгийн, Согог дунд сургуулиас 9,4 сая төгрөгийн, Хүүхдийн цэцэрлэгээс 8,2 сая төгрөгийн, Согог хүүхдийн цэцэрлэгээс 1,7 сая төгрөгийн, ТТЗ-ийн СНТайлангаас 323,9 сая төгрөгийн алдаа зөрчил илэрсэн байна.

Сумын санхүүгийн алба нь санхүүгийн албаны дарга 1, төрийн сангийн төлөөлөгч 1, нягтлан бодогч 3 бүгд 5 орон тоогоор үйл ажиллагаагаа явуулж, нягтлан бодогчид төсвийн 10 байгууллага, 3 санг хариуцаж ажилласан байна.

Нягтлан бодогч С.Сарай нь 3 байгууллага, 1 санг, нягтлан бодогч Ш.Ахбөпе нь 4 байгууллага, нягтлан бодогч Б.Айнур нь 3 байгууллага, 1 сан, төрийн сангийн төлөөлөгч Е.Пернегул 1 санг хариуцаж ажиллаж ирсэн байна.

Дээрхи байдлаас дүгнэлт хийж үзэхэд санхүүгийн албаны нягтлан бодогч нарын ажлын ачааллыг жигд хуваарилаагүй, ажил үүргийн хуваарь оновчгүй хийгдсэн байна. Энэ нь ажлын ачаалал хэтэрсэн нягтлан бодогч нарын санхүүгийн тооцоо хийх, нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан гаргах, цаг хугацаанд нь тайлагнах, тушаах зэрэгт ихээхэн хүндрэл учруулдаг байна. Иймээс санхүүгийн албаны нягтлан бодогч нарын ажил үүргийн хуваарийг оновчтой болгох шаардлагаа үүсч байгааг анхаарах цаг болсон байна.

Нягтлан бодогчдын хариуцаж байгаа байгууллагыг хүснэгтээр харуулбал

№	Нэр	С.Сарай	Ш.Ахбөпе	Б.Айнур	Е.Пернегул
1	ИТХурал			1	
2	ЗДТГазар			1	
3	Бүрэн дунд сургууль		1		
4	Хөххөтөл дунд сургууль	1			
5	Согог дунд сургууль		1		
6	Хүүхдийн цэцэрлэг	1			
7	Хөх хөтөл хүүхдийн цэцэрлэг		1		
8	Согог хүүхдийн цэцэрлэг		1		
9	ЭМТөв	1			
10	Соёлын төв			1	
11	Орон нутгийн хөгжлийн сан			1	
12	Сум хөгжүүлэх сан				1
13	Эргэлтийн эмийн сан	1			
	Дүн	4	4	4	1

3 МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналийн бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга Аудитын олон улсын стандарт болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Улаанхус сумын ТТЗНСТайлангийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаархи бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдолтойгоос нь эхлэн эрэмбэлэн үзүүлэв.

3.1 Асуудал 1: Санхүүгийн тайлагнал

3.2 Тэргүүлэх ач холбогдол №2

БӨ АГ-ын ажиглалт

